



СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.26 №17 (17)

ҮЙЛ ЯВДАЛ

ЯАМДЫН ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАР ЦЭРЭГ-СТРАТЕГИЙН БЭЛТГЭЛ СУРГАЛТАД ХАМРАГДАЖ БАЙНА



Дайчилгааны тухай болон Цэргийн албаны тухай хуульд заасны дагуу яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарын "Цэрэг-стратегийн бэлтгэл" сургалтыг Батлан хамгаалах яам 3 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Тус сургалт нь шинээр томилогдсон Төрийн нарийн бичгийн дарга нартай анх удаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд Батлан хамгаалахын шинэ эрх зүйн орчинд явагдаж байгаа гэдгээрээ онцлогтой. "Цэрэг-стратегийн бэлтгэл" сургалт нь 2003 оноос

хойш уламжлал болон явагдаж байгаа бөгөөд батлан хамгаалах бодлого, зорилгыг хэрэгжүүлэх, Төрийн нарийн бичгийн дарга нарыг батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний талаар шинэ мэдээ, мэдээллээр хангасан чухал ач холбогдолтой сургалт болж байгаа

юм. Арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, яамдын Төрийн нарын бичгийн дарга нар болон БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа С.Ганбямба, ТЗУГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа нар оролцлоо. Тус сургалтыг Батлан хамгаалахын сайд нээж хэлсэн үгэндээ "Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан батлан хамгаалах хууль, тогтоомжууд ялангуяа Орон нутгийн хамгаалалтын тухай болон Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдан гарсантай холбогдуулан нэлээдгүй дүрэм, журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулж төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг нарийвчлан тогтоох юм. Тиймээс энэ удаагийн Төрийн нарийн бичгийн дарга нартай явуулах "Цэрэг-стратегийн бэлтгэл" сургалт нь төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд хүргэхэд ихээхэн дэмжлэг болно" хэмээн онцолж, сургалтад оролцогсод амжилт хүслээ.

Тус сургалтаар Монгол Улсын аюулгүй байдал, аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлтүүд, батлан хамгаалах бодлого, эрх зүйн шинэчлэлт, Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг, шинэчлэлтийн талаар болон төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд хүргэх зэрэг олон чухал сургалтууд багтах юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 9°C	☁️ -2°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36°C	☁️ 25°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17°C	☁️ 5°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,343.0	3,408.0
CNY 🇨🇳	434.50	438.90
RUB 🇷🇺	36.40	38.14
JPY 🇯🇵	25.91	26.54
KRW 🇰🇷	2.45	2.57

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	285
НИЙТ БҮРТГЭГДСЭН	5895
ЭДГЭРСЭН	4044
НАС БАРСАН	9

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	13
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	246
ЭДГЭРСЭН	1050
НИЙТ БАТЛАГДСАН	1296

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.26
/БААСАН ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулвал:
Жаргал ирнэ

Наран ургах, шингэх:
06.43-19.13

Барилдлага: Түлэх

Шүтэн барилдлага: Төрөн түгэхүй

Суудал: Уул

Аргын тооллын 3 сарын 26, Сугар гараг. Билгийн тооллын 13, Их морь одтой, харагчин тахиа өдөр. Өдрийн наран 6 цаг 43 минутад мандан, 19 цаг 13 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, лусыг тахиж, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогдод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЧИЛ ҮЗЭСГЭЛЭН ДҮНЖИНГАРАВТ СААТАЖ БАЙНА



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан ард иргэдэд Зэвсэгт хүчний түүхэн замнал, баатарлаг үйлсийг таниулах, танин мэдэх хүсэл эрмэлзлийг төрүүлэх зорилгоор ЗХЖШ, "Дүнжингарав" худалдааны төвтэй хамтран бичил үзэсгэлэнг тус

худалдааны төвд дэлгэлээ. Үзэсгэлэнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг харуулсан үзүүлэн, Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн замналыг талаарх зурагт самбарыг байршуулжээ. Уг үзэсгэлэн 3 дугаар сарын 29-ний өдөр хүртэл үргэлжлэх юм.

ЦЭРГИЙН ШТАБ 100 ЖИЛД...

ХАМГИЙН ОЛОН ШАГНАЛТ БАЙРЫГ ТУС ДҮҮРЭГ ЭЗЛЭВ

Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг дүүргийн хэмжээнд халдвар хамгаалалтын дэглэмийг баримтлан тэмдэглэн өнгөрүүлээ. Дүүргийн Ерөнхий боловсролын 18 сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Эрхмийн дээд Монгол эр хүн" сэдэвт зохион бичлэгийн уралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж шилдгүүдийг шалгаруулав. Тус уралдааны эхний шатанд нийт 40 орчим сурагчдын бүтээл ирүүлснээс "Эрхэт ист" сургуулийн 12 дугаар ангийн сурагч Н. Тамир, "Ган зам" 20 дугаар сургуулийн 12г ангийн сурагч Х. Алюнаа, 12б ангийн сурагч Н. Дуламсүрэн, 3.Анужин нарын бүтээлүүд тус тус шалгарав. "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдаанд дүүргийн хэмжээнд идэвхтэй оролцохын зэрэгцээ хамгийн олон шагналт байрын тус дүүргийн сурагчид хүртжээ. Мөн дайчилгаа удирдах

бүлгийн гишүүдийн дунд байлдааны буудлагын "Скат" тэмцээнийг Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулж, шилдгүүдийг шалгаруулав. Дүүргийн Засаг дарга болон Цэргийн штабын бүрэлдэхүүн 2020 оны 2 дугаар ээлжээр татагдан очсон хугацаат цэргийн алба хаагчдаа эргэж, ар гэрийнхэнд нь тэдний талархлын захидлыг хүргэхээс гадна зарим өрхүүдэд мөнгөн дэмжлэг үзүүлэв.

Цаашид тус Цэргийн штаб Монгол Улсад "Генерал цолтон" бий болсны 77 жилийн ойд зориулан дүүргийн генералуудад хүндэтгэл үзүүлэх, "Энхийг сахиулагчдын өдөр"-өөр олон улсын цэргийн ажиллагаанд оролцсон энхийг сахлагчдаа сурталчлахын зэрэгцээ Цэргийн штабын байрны коридорт алдрын булан байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг ирэх саруудад зохион байгуулахаар төлөвлөжээ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ӨНӨӨДӨР МАШ ХҮЧТЭЙ ШОРООН БОЛОН ЦАСАН ШУУРГА БОЛНО

Цаг Уур Орчны Шинжилгээний газраас дараах сэрэмжлүүлэг анхааруулгыг иргэдэд хүргэж байна. Өнөөдөр Баян-Өлгий, Ховд, Говь-Алтайн нутаг, Увсын өмнөд, Завханы баруун хэсгээр салхи секундэд 18-20 метр, зарим үед секундэд 24 метрийг даван салхилж, шороон шуурга Аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч шуурна. Мөн Увс, Завханы хойд хэсгээр, 27-нд нутгийн төв хэсгээр нойтон цас, цас орж, цасан шуурга шуурч, ихэнх нутгаар хүчтэй салхи, шороон шуургатай байхыг онцгойлон анхааруулж байна. Иймд Та бүхэнд хүчтэй шороон болон цасан шуурганы үеэр иргэн

бүр зайлшгүй анхаарах зөвлөмжийг хүргэж байна. - Цаг агаарын мэдээ, мэдээллийг цаг тухай бүр сонсон, мэргэжлийн байгууллагаас өгч буй сэрэмжлүүлэг, анхааруулгыг дагах, - Цас орох нутгуудаар хальтиргаа гулгаа үүсч болзошгүй анхааран тээврийн хэрэгслийн жолооч нар хол, ойрын замд гарахдаа тээврийн хэрэгслийн найдвартай байдлыг хангаж бензин, шатахууны нөөцтэй, дулаан хувцастай зорчих, - Иргэд, малчид болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, салхи шуурганд төөрөх, малтайгаа уруудах эрсдэлээс урьдчилан сэргийлж, малаа ойрын бэлчээрт хариулах, бага насны хүүхдийг малд явуулахгүй байхыг анхааруулж байна.



Дэд хурандаа Д.ЭРДЭНЭБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧЛАХ ОЛОН ТӨРЛИЙН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Ховд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалах яамны 110 жил, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 123 дугаар анги, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, орон нутгийн удирдлага, байгууллагуудтай хамтран орон нутагт Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, өсвөр үеийнхэнд цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж явууллаа. Тухайлбал, Монгол Улсад "Хурандаа" цол бий болсны түүхт 85 жилийн ойг тохиолдуулан Ховд аймагт ажиллаж амьдарч байгаа бэлтгэл, чөлөөнд байгаа болон одоо ажиллаж байгаа "Хурандаа" нарыг аймгийн удирдлагууд хүлээн хүндэтгэл үзүүлсэн ба энэ үеэр Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагчийн нэрэмжит буудлагын тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээн 9мм-ийн ПМ гар буу болон 7,62мм-ийн АКМ автомат бууны төрлүүдээр зохион байгуулж явуулсан бөгөөд нийт 18 хурандаа оролцож оюун ухаан, цэц мэргэнээ сорин өрсөлдсөнөөс Ховд аймаг дахь Шүүх шинжилгээний албаны дарга цагдаагийн хурандаа Б.Цэрэндорж, Хилийн цэргийн 0130 дугаар ангийн захирагч хурандаа Э.Баярхүү, бэлтгэл хурандаа Г.Ганболд нар эхний гурван байрт шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

Мөн Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот уулархаг газар орон дээр давших байлдааныг зохион байгуулж явуулах" сэдвээр мотобуудлагын ротын байлдааны буудлагыг явуулав. Тус сургалт, дадлагыг аймгийн удирдлагууд болон төрийн цэргийн байгууллагуудын удирдлага, алба хаагчид үзэж сонирхов.


Зэвсэгт хүчний 123 дугаар анги 2020 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 35 сая төгрөгөөр шинээр тохижуулсан "Бялдаржуулах танхим"-ын нээлтийн үйл ажиллагааг түүхт ойн өдөр зохион байгууллаа.

Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойг тохиолдуулан Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас санаачлан энэ өдөр мэндэлж төрсөн өдрөө тэмдэглэж буй Ховд аймгийн Жаргалант сумын иргэн Б.Нямсүрэн, Г.Нямсансар нарыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн цаашдын ажил, амьдралд нь амжилт хүслээ. Энэ үеэр иргэн Б.Нямсүрэн, Г.Нямсансар нар цаашид цар тахлын нөхцөл байдал намжсаны дараа түүхт өдрийг тохиолдуулан тус Цэргийн штабтай хамтран хүүхэд, залуучуудад энэхүү "Монгол хүн сансарт ниссэн өдөр"-ийг сурталчлах чиглэлээр тодорхой арга хэмжээг зохион байгуулах талаар тодорхой саналтай байгаагаа илэрхийлсэн бөгөөд жил бүр хамтарч ажиллаар тохиролцлоо.

Дэд хурандаа Б.МӨНГӨНЦООЖ



ИРЭХ САРД ҮЙЛДЭХ ТУСГАЙ НИСЛЭГИЙН ХУВААРЬТ ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО



Ирэх сард хийхээр төлөвлөгдсөн тусгай үүргийн нислэгийн хуваарьт зарим өөрчлөлт орлоо. Мөн Засгийн газраас Монгол Улсын хилийг 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шат дараатай нэхээр төлөвлөж байгаатай холбоотойгоор 4 дүгээр сард зарласан тусгай үүргийн нислэгээр Сөүлээс бусад чиглэлээс ирэх иргэд тийзээ шууд авиакомпаниудад хандан худалдан авах энгийн горимд шилжиж байна. Үүнд зөвхөн транзит зорчигч авах Сөүл-Улаанбаатар чиглэлийн 04.23-ны нислэг мөн хамаарна.

Түүнчлэн Сөүл-Улаанбаатар чиглэлд хийгдэх 04.14-ний өдрийн Асиана Эйрлайнс, 04.28-ны өдрийн Корейн Эйр компанийн нислэгээр тус тус ирэх хүсэлтэй Солонгост байгаа иргэд мөн эдгээр компанид шууд хандан тийзээ авч болно.

Харин МИАТ компанийн Сөүл-Улаанбаатар чиглэлийн нислэгийн зорчигчийн нэрсийг ЭСЯ-нд хандан иргэдийн гаргасан өргөдлийн дарааллаар Сөүл дэх МИАТ компанийн төлөөлөгчийн газарт хүргүүлж баталгаажуулах юм.

АНХНЫ ДАДЛАГА АМЖИЛТТАЙ ЯВАГДАВ

Зэвсэгт хүчний 017 дугаар анги

Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн материаллаг баазыг түшиглэн ангийн "Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг "Мотобуудлагын рот хориглох байлдааныг бэлтгэж явуулах"-сэдвээр амжилттай зохион байгууллаа. Сургуулийг ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн хурандаа Ш.Гантулга, Барилга Инженерийн Цэргийн Удирдах газрын орлогч дарга хурандаа Ц.Ганхөлөг болон бусад албаны хүмүүс цахимаар

үзэж сонирхон саналаа хэлж, үүрэг даалгавар өглөө. Уг байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль нь ангийн түүхэнд анхных гэдэг утгаараа онцлогтой болсон бөгөөд бие бүрэлдэхүүний цэргийн хээрийн онол, дадлага, мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн өндөр ач холгогдолтой сургууль болсон. Цаашдаа жил бүр төлөвлөн зохион байгуулах зорилт тавин ажиллаж байна. Тус сургалт дадлагыг Онцгой Комиссоос гаргасан халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдлөг болгон ажилласан юм.

Ахмад С.Уламбаяр

СУРГАЛТ, ДАДЛАГА

ХИМИЙН НЭГДСЭН ХЭЭРИЙН ГАРАЛТ, ДАДЛАГА СУРГУУЛИЙГ ЯВУУЛАВ



Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн сургалтын төвд Улаанбаатар цэргийн хүрээний химийн анги, салбаруудын "Химийн нэгдсэн дадлага, сургууль"-ийг 7 өдрийн турш зохион байгуулж явууллаа. Дээрх дадлага сургуульд 011, 015, 084, 119, 150, 326, 350, 353 зэрэг 9 ангийн 100 гаруй офицер, ахлагч, 30 гаруй нэгж химийн тусгай тоноглолтой авто, хуягт техникүүдийг татан оролцууллаа.

Цацраг, хими, биологийн тагнуул, Зэвсэг, техник цэвэрлэх, хувцас тоног хэрэгсэл цэвэрлэх, Ариутгал, ТМС-65 цэвэрлэгээний техникийн операторуудыг бэлтгэх гэсэн 5 хичээлийн цэгт 5 бүлэгт хуваагдаж өдрийн 10 цагаар тус сургалт дадлагыг зохион байгуулсан

юм. Цацраг, хими, биологийн тагнуулын хичээлийн цэгт цацраг, химийн тагнуулын машинаар зам маршрут, газар оронд цацраг, химийн тагнуулыг явуулах, тусгай тоног, тагнуулын багажуудыг ашиглан норматив биелүүлэх, тагнуулд үүрэг гүйцэтгэсний дараа тасгийн ажиллагаа, багажид үйлчилгээ хийх, хамгаалах хэрэгслийг өмсөх тайлах дараалал зэрэг цэргийн тактикийн ажиллагаанд тулгуурлан сургалт дадлагуудыг явуулав.

Зэвсэг техник цэвэрлэх хичээлийн цэгт ангиуд өөрсдийн орон тооны техник /АРС-14у/-ийг ашиглан цэвэрлэгээний бодис уусмалыг найруулах, газар орон, зэвсэг техник цэвэрлэгээ

хийх норматив биелүүлэх, хамгаалах хэрэгслийг өмсөх тайлах дараалал, тасаг бүлгээр ажиллах байдлаар сургалт, дадлагыг зохион байгуулсан.

Хувцас, тоног, хэрэгсэл цэвэрлэх хичээлийн цэгт цэвэрлэгээний техникийг ашиглах, хордсон хувцас хэрэглэлийг ариутгах, буцалгах суурийг ашиглан тоног

хэрэгсэлд ариутгал хийх, тасаг тоот норматив гүйцэтгэх, дэлгэх, хураах байдлаар сургалтыг явуулсан.

Түүнчлэн дээрх сургалт, дадлагад Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн офицер ахлагч нар түлхүү оролцсон бөгөөд Зэвсэгт хүчний бусад ангиудад танилцуулах, тактикийн ажиллагааг үзүүлэх зорилгоор онолын болон дадлагыг сургалтыг давхар явууллаа.

Харин ариутгалын хичээлийн цэгт ангиуд өөрсдийн орон тооны ариутгалын техникийг ашиглан ариутгалын байр дэлгэх, хураах, уурын тогоонд даралт үүсгэх, инжекторыг ажиллуулах, ариутгалын камерт хордсон хувцас ариутгах, норматив биелүүлэх, хамгаалах

хэрэгслийг өмсөх тайлах дараалал, тасаг бүлгийн тактикийн ажиллагаа гүйцэтгэх зэрэг тасгийн жигдрэлтийг хангах сургалт, дадлага явагдав. Цэвэрлэгээний техникийн операторуудыг бэлтгэх хичээлийн цэгийн багшаар ахмад Б.Анхбаяр удирдан 4 хүний бүрэлдэхүүнтэй цэвэрлэгээ ариутгалын техникийн оператор бэлтгэх сургалтыг зохион байгуулж явуулсан. Сургалтаар ТМС-65 техникийн үүрэг зориулалт, ВК-1А хөдөлгүүрт үйлчилгээ хийх дараалал, тусгай тоногуудын ажиллах зарчим, газар орон, техникт хий болон хий-шингэний аргаар цэвэрлэгээ хийх ажиллагаа, аюулгүй ажиллагаа зэрэг нийт 50 цагийн сургалт явагдсан юм. Нэгдсэн хээрийн дадлага, сургуульд Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн хөдөлгөөнт химийн засварын цехийг

оролцуулан ангиудын химийн техникүүдэд үзлэг явуулж, тусгай тоногийг засварлах ажлыг хийсэн. Мөн засварын ажилд Зэвсэгт хүчний 119, 150, 326, 350, 353 дугаар ангиудын нийт 12 нэгж химийн техникүүдийн тусгай тоногийг засварласан юм.

Хээрийн нэгдсэн дадлага, сургалтыг коронавирус, цар тахлын үед зохион байгуулж явуулснаар ариутгал, цэвэрлэгээний бүлгүүд бодит цагийн байдлыг үнэлэн Төв аймгийн Алтанбулаг сумын байрлалд /сумын ЗДТГ, Хаан банк, төрийн банк, төв зам, эмнэлэг, ажилчдын байр, сургууль, хүн ихээр төвлөрдөг дэлгүүр/ зам талбайн ариутгалыг хийж сум орон нутгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн юм.



Хошууч Б.ТҮВШИНЖАРГАЛ



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАЛАМБА,
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг "Соёмбо" сонин редакция бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029